

**ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН  
2019 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН,  
ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН САНХҮҮГИЙН  
ТАЙЛАНГИЙН АУДИТ**

## АГУУЛГА

Товчилсон үгийн жагсаалт.....	1
1.Аудитын гэрчилгээ .....	2
2.Аудитын тайлан.....	4
2.1. Оршил .....	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	4
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт .....	4
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин .....	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ .....	6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал .....	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар .....	6
2.8. Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлтүүд .....	6
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	7
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	7
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал .....	8
2.12. Шилэн дансны мэдээлэл.....	8
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт .....	8
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	8
3. Менежментийн захидал .....	9
4.Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан.....	12
4.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан.....	12
4.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан .....	13
4.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	14
4.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	15
4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	16
5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....	18

## Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
СЕХ	Сонгуулийн ерөнхий хороо
ТЕГ	Тагнуулын ерөнхий газар
УБЕГ	Улсын бүртгэлийн ерөнхий газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал



## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:51-26-42-30  
E-mail: info@audit.gov.mn

СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРООНЫ  
ДАРГА Ч.СОДНОМЦЭРЭН ТАНАА

2020.04.24 № 1316  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Сонгуулийн ерөнхий хорооны даргын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

### Зөрчилгүй санал дүгнэлт

Сонгуулийн ерөнхий хорооны даргын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу үнэн, бодит, шударга, илэрхийлсэн байна.

### Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн нэгтгэсэн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Сонгуулийн ерөнхий хорооны даргын 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэлтэй санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

## Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.3-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн нэгтгэсэн тайлан тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлсэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.



Д.ЗАНДАНБАТ

## **2.Аудитын тайлан**

### **2.1. Оршил**

Сонгуулийн ерөнхий хорооны даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Сонгуулийн ерөнхий хорооны дарга Ч.Содномцэрэн танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн санхүүгийн тайланд бүртгэлээр тавих дотоод хяналтыг сайжруулах, цалингийн программ ашиглах, Засгийн газрын тогтоолыг хэрэгжүүлэн ажиллах зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

### **2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага**

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Сонгуулийн ерөнхий хорооны даргын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сонгуулийн ерөнхий хорооны даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн ерөнхийлөн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 4 дүгээр сарын 06-аас 2020 оны 4 дүгээр сарын 23-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 4 дүгээр сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор П.Чанцалдулам хариуцаж хэрэгжүүлэв.

Сонгуулийн ерөнхий хорооны даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2020 оны 3 дугаар сарын 11-ний өдрийн 1/67 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

### **2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт**

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

## 2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Сонгуулийн ерөнхий хорооны үндсэн зорилго нь Монгол Улсын Их Хурлын болон Ерөнхийлөгчийн сонгууль, Ард нийтийн санал асуулгыг бэлтгэн явуулах ажлыг төлөвлөж, зохион байгуулах, сонгуулийн хороодыг нэгдсэн удирдлагаар хангах, аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийг зохион байгуулж явуулах ажлыг мөргөжил, арга зүйн удирдлагаар хангахад оршиж байна.

Сонгуулийн ерөнхий хороо дээрх чиг үүргийг хэрэгжүүлэх зорилгоор тайлант хугацаанд явуулсан үйл ажиллагаа, түүний үр дүнгийн талаар хураангуйлан тэмдэглэв.

Сонгуулийн ерөнхий хороо тайлант хугацаанд төлөвлөсөн ажлаа дараах чиглэлээр дэлгэрэнгүй тайлагнасан бөгөөд Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуулийн 1 дүгээр хавсралтаар Сонгуулийн ерөнхий хорооны даргын 2019 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, түүний хүрэх үр дүнгийн зорилтот түвшнийг 6 үзүүлэлтээр баталгаажуулсныг дараах гүйцэтгэлтэй хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- Сонгуулийн хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбоотой боловсруулах журам, заавар, маягт 20 байхаар төлөвлөж, Монгол Улсын Их хурлын сонгуулийн тухай хуулийн төслийн 12 бүлэг 83 зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын сонгуулийн тухай хуулийн төслийн 12 бүлэг 83 зүйл, Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн төслийн 11 бүлэг 80 зүйлд санал боловсруулсан;
- Сонгуулийн хууль тогтоомжийг сурталчлах сургалт, семинарыг 3 удаа зохион байгуулахаар төлөвлөж, 4 удаагийн сургалт зохион байгуулсан;
- Сонгогчдын боловсролыг дээшлүүлэх, өмнөх оны суурь үзүүлэлтээс 5.0 хувиар өсөхөөр төлөвлөж, биелэлт 5.1 хувьтай;
- Сонгуулийн хорооны үйл ажиллагаанд 10 удаа хяналт, шалгалт хийхээр төлөвлөж, 16 удаа гүйцэтгэсэн;
- Сонгуулийн автоматжуулсан системийг бүрэн ашиглах, хэвийн үйл ажиллагаа, санал хураах тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг хангах тоо 5000 байхаар төлөвлөж, 2500 ширхэг батарей, 2500 ширхэг санал тоолох төхөөрөмжийг шалгах, цэнэглэх ажлыг хуваарийн дагуу зохион байгуулж, бэлэн байдлыг хангаж ажилласан байна. Сонгуулийн автоматжуулах системийн иж бүрдлийн нэг хэсэг болох сонгогчийн бүртгэлийн системд ашиглах зөөврийн компьютер худалдан авах ажиллагааг зохион байгуулж, УБЕГ-т 2400 ширхэг зөөврийн компьютерыг хүлээлгэн өгсөн;
- Программ хангамжийн аюулгүй ажиллагааг бүрэн хамгаалсан байх үүргээ 100 хувьтай тус тус гүйцэтгэсэн байна.

Сонгуулийн ерөнхий хороо нь санхүүгийн үйл ажиллагаандаа Монгол Улсын Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай болон бусад холбогдох хуулиуд, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /УСНББОУС/, Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”, 2015 оны “Төсвийн ангилал шинэчлэн батлах тухай” 7 дугаар тушаал зэрэг эрх зүйн актуудыг мөрдөж байна.

Сонгуулийн ерөнхий хорооны даргын 2013 оны 02, 03 дугаар тогтоолоор Сонгуулийн ерөнхий хорооны даргын бүтэц, орон тооны хязгаарыг 33 байхаар баталсан байна.

Сонгуулийн ерөнхий хорооны даргын үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд төлөвлөсөн хэмжээнд судалж, баримтжуулсан.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Нийгмийн даатгалын тухай хуулиар нийгмийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээ өөрчлөгдсөн;
- Зам тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 390 дүгээр тушаалаар шинэчлэн баталсан “Жишиг норм”;

## 2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн нэгтгэсэн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Сонгуулийн ерөнхий хороо нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд Санхүүгийн тооцоолох групп ХХК-ний "Acoulous 3.0" програм хангамж ашигладаг байна.

Сонгуулийн ерөнхий хорооны дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд "Бага" гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

## 2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Сонгуулийн ерөнхий хорооны даргын бэлтгэсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 7 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

## 2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшнийг бага гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 5,238.6 сая төгрөгөөс 2 хувиар тооцон 104.8 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажуулсан бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг өөрчлөөгүй болно.

## 2.8. Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлтүүд

Сонгуулийн ерөнхий хорооны даргын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 109.2 сая төгрөгөөр буюу 8.0 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/сая төгрөг/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Бараа материал	1,142.9	1,042.8	-100.1
Үндсэн хөрөнгө	14,208.6	14,274.2	65.6
Хуримтлагдсан элэгдэл	-13,982.7	-14,057.4	-74.7
<b>Нийт хөрөнгө</b>	<b>1,368.8</b>	<b>1,259.6</b>	<b>-109.2</b>
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	14,410.8	14,410.8	-
Хуримтлагдсан үр дүн	-13,043.2	-13,152.4	-109.2
Дахин Үнэлгээний зөрүү	1.2	1.2	-
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>1,368.8</b>	<b>1,259.6</b>	<b>-109.2</b>



Бараа материалын дансны үлдэгдэл буурсан нь өмч хамгаалах байнгын зөвлөлийн 2019 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн санал дүгнэлтийг үндэслэн СЕХ-ны Ажлын албаны даргын 2019 оны А/14, СЕХ-ны дэргэдэх Мэдээлэл, технологийн төвийн захирлын 2019 оны А/04 дүгээр тушаалуудаар нийт 92.1 сая төгрөгийн 2,501 ширхэг бараа материалыг акталснаас шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 65.6 сая төгрөгөөр нэмэгдсэн нь тайлант онд нийт 40 ширхэг зөөврийн компьютерыг дагалдах хэрэгслийн хамт төсвийн хөрөнгө оруулалтаар худалдан авсантай холбоотой байна.

Мөн хөрөнгө оруулалтаар 3,933.2 сая төгрөгийн 2400 ширхэг зөөврийн компьютерыг дагалдах хэрэгслийн хамт худалдан авч, ТӨБЗГ-ын 2019 оны “Үндсэн хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай” 453 дугаар тогтоол, СЕХ-ны даргын 2019 оны А/11 дүгээр захирамжаар тус хөрөнгийг Улсын бүртгэлийн ерөнхий газарт балансаас балансад шилжүүлсэн байна.

Засгийн газрын оролцоо буюу цэвэр хөрөнгө өмчийн дансны үлдэгдэл 1,259.6 сая төгрөг болж 109.2 сая төгрөгөөр буурсан нь тайлант оны үр дүнтэй холбоотой байна.

## **2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсөв захирагч нь төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд Төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөр, арга хэмжээнд зориулан нийт 5,130.5 сая төгрөгийн төсөв батлагдсанаас урсгал зардалд 1,130.5 сая, хөрөнгө оруулалтын зардалд 4,000.0 сая төгрөг зарцуулахаар төлөвлөжээ.

Улсын төсвөөс 5,129.3 сая төгрөгийн санхүүжилт олгож, тайлант оны эцэст 173.4 сая төгрөгийг татан төвлөрүүлсэн байна.

Тайлант онд 0.1 сая төгрөгийн тендерийн орлогыг туслах үйл ажиллагааны орлогод бүртгэж, зарцуулсан байна.

Нийт зардлын гүйцэтгэл 4,956.1 сая төгрөг буюу 96.6 хувьтай ба зарцуулагдаагүй үлдэгдэл 174.4 сая төгрөг байна.

Урсгал зардлын гүйцэтгэл 84.7 хувьтай буюу 957.3 сая төгрөг байгаа нь бараа үйлчилгээний бусад зардал 128.7 сая, хичээл үйлдвэрлэлийн дадлага 8.7 сая, цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал 28.6 сая төгрөгөөр тус тус дутуу зарцуулагдсанаас шалтгаалжээ.

Хөрөнгө оруулалтын зардлаас 99.9 хувь буюу 3,998.8 сая төгрөгийг зарцуулсан нь хөрөнгө оруулалтын арга хэмжээнд тусгагдсан ажлыг бүрэн хэрэгжүүлсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

## **2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн**

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 7 эрсдэлтэй асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 37.7 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 1.2 сая төгрөгийн алдааг залруулж, 36.5 сая төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 4 зөвлөмж өглөө. Үүнд:

1. Сонгуулийн ерөнхий хорооны даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан болон төсвийн шууд захирагчдын санхүүгийн тайлан, тодруулга, хоорондын тооцоо, устгах



бичилтийг шалгахад тооцооллын ямар нэгэн алдаа илрээгүй боловч төсвийн гүйцэтгэлийн тайлангийн төлөвлөгөөг Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуулиар баталсан дүнгээс 1.2 сая төгрөгөөр дутуу бүртгэж, тайлагнажээ.

Шийдвэрлэсэн нь: Аудитын явцад санхүүгийн нэгтгэсэн тайланг залруулсан.

Аудитаар илэрсэн 36.5 сая төгрөгийн алдаа, зөрчилд 4 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

## **2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал**

Санхүүгийн нэгтгэсэн тайланд 2019 оны төсвийн төсөлд санал өгөөгүй боловч хуулиар хөрөнгө оруулалтын санхүүжилтэд 4,000.0 сая төгрөг батлагдаж, худалдан авах ажиллагааг зохион байгуулан, 2400 ширхэг зөөврийн компьютерыг дагалдах хэрэгслийн хамт худалдан авч, ТӨБЗГ-ын 2019 оны “Үндсэн хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай” 453 дугаар тогтоолоор уг хөрөнгийг Улсын бүртгэлийн ерөнхий газарт балансаас балансад шилжүүлсэн байгаад хөрөнгө оруулалтын аудитаар анхаарал хандуулбал зохилтой байна.

## **2.12. Шилэн дансны мэдээлэл**

Сонгуулийн ерөнхий хорооны даргын Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 76 мэдээллийг хугацаанд нь, 1 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, 2 мэдээллийг байршуулаагүй бөгөөд цалингаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш дүнтэй нийт 86 ширхэг 5,049.7 сая төгрөгийн орлогын, 4,231.6 сая төгрөгийн зарлагын ажил гүйлгээг мэдээлсэн байна.

## **2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар Сонгуулийн ерөнхий хорооны даргад Үндэсний аудитын газраас итгэл үзүүлсэн байна.

## **2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

Бид Сонгуулийн ерөнхий хорооны даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Аудитаар залруулагдаагүй 36.5 сая төгрөгийн алдаа, зөрчил нь бидний тогтоосон 104.8 сая төгрөгийн материаллаг байдлын түвшнээс бага байгаа тул “Зөрчилгүй” дүгнэлт өгч байна.

Сонгуулийн ерөнхий хорооны даргын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдал, санхүүгийн нэгтгэсэн үр дүн, нэгтгэсэн мөнгөн гүйлгээ, нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

### **3. Менежментийн захидал**

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд Менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн нэгтгэсэн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн нэгтгэсэн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

#### **3.1 Балансын данстай холбоотой асуудал**

##### **3.1.1 Илрүүлэлт:**

СЕХ болон СЕХ-ны дэргэдэх Мэдээлэл, технологийн төвийн 2019 оны санхүүгийн тайланд тайлагнагдсан бараа материалын үлдэгдэл, хөрөнгийн хөдөлгөөнийг тооллогын тайлан, бүртгэлтэй тулгахад СЕХ-ны ажлын алба 11.8 сая, Мэдээлэл, технологийн төв 2.2 сая төгрөгийн хөрөнгийг худалдан авч, зарцуулсан хөдөлгөөнийг тус бүр тооллогын бүртгэлд дутуу бүртгэж, зөрүүтэй тайлагнасан нь үнэн зөв байдал "Аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайланд тусгасан ажил гүйлгээ, үлдэгдэл нь тооцооллын алдаагүй, зөв хураангуйлж бүртгэсэн болон түүнийг зохицуулж буй хууль тогтоомжуудтай нийцэж байх" гэсэн батламж мэдэгдэл, НББ-ийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д "Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэсэнтэй нийцэхгүй байна.

##### **3.1.2 Эрсдэл:**

Санхүүгийн нэгтгэсэн тайлан үнэн зөв илэрхийлэгдэхгүй, бүртгэлээр тавих хяналт сул байх

##### **3.1.3 Өгсөн зөвлөмж:**

Нягтлан бодогчийн хариуцлагыг сайжруулж, бүртгэл, тайлан мэдээг үнэн зөв боловсруулж байх;

##### **3.1.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:**

Аудитаар гарсан алдаа, зөрчлийг хүлээн зөвшөөрч зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

### **3.2 Балансын данстай холбоотой асуудал**

#### **3.2.1 Илрүүлэлт:**

СЕХ-ны дэргэдэх Мэдээлэл, технологийн төвийн 2019 оны санхүүгийн тайланд 2012 онд худалдан авсан, 2015 онд элэгдлээрээ өртгөө бүрэн нөхсөн, ашиглах боломжгүй болсон, нийт 17.5 сая төгрөгийн өртөгтэй албан хэрэг хөтлөлт, сонгогчийн бүртгэлийн серверийн программ хангамжууд бүртгэлтэй байгаа цаашид ашиглагдахгүй хөрөнгө байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1-д "Төрийн өмчит хуулийн этгээд эзэмшилдээ байгаа илүүдэл үндсэн эд хөрөнгө, түүнчлэн ашиглах хугацаа нь дууссан буюу эсхүл осол гэмтэлд өртсөний улмаас зориулалтаар нь ашиглах боломжгүй болсон бөгөөд засаж, сэлбэж ашиглах нь эдийн засгийн хувьд үр ашиггүй нь тооцоогоор нотлогдсон эд хөрөнгийг худалдаж, шилжүүлж, акт тогтоон устгаж болно", 31.3-т "Засаж сэлбэн ашиглах боломжгүй эд хөрөнгийг акталж устгах" гэснийг хэрэгжүүлээгүй байна.

#### **3.2.2 Эрсдэл:**

Тооллогын комисс ашиглах боломжгүй хөрөнгийг данс бүртгэлээс хасуулах тухай хүсэлтийг ТӨБЗГ-т хүргүүлээгүй байх, хэрэгцээ шаардлагагүй хөрөнгийн дүнгээр балансын дансны үлдэгдэл нэмэгдэх

#### **3.2.3 Өгсөн зөвлөмж:**

Ашиглах боломжгүй хөрөнгийг данс бүртгэлээс хасах санал боловсруулж, ТӨБЗГ-т санал хүргүүлэн шийдвэрлүүлэх;

#### **3.2.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:**

Аудитаар гарсан алдаа, зөрчлийг хүлээн зөвшөөрч зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

### **3.3 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл**

#### **3.3.1 Илрүүлэлт:**

Нийт урсгал зардлын гүйцэтгэлийн 47.0 хувь буюу 450.2 сая төгрөг нь цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардал байна. СЕХ болон СЕХ-ны дэргэдэх Мэдээлэл, технологийн төвийн ажилчдын цалин хөлсний тооцооллыг хянахад Санхүүгийн тооцоолох группийн "Acolous" программыг ашиглаж, гэрээний дагуу нэмэлт үйлчилгээг авч байгаа боловч цалинг цалингийн программаар бус excel дээр тооцоолсон, мөн ажиллагсдын цалингийн нэмэгдлийг салгалгүйгээр бөөн дүнгээр тооцсон нь цалингийн тооцооллыг шалгахад хүндрэлтэй бөгөөд цалинг илүү, дутуу тооцож олгох, тооцооллын алдаа үүсэх эрсдэлтэй байна. Энэ нь НББ-ийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.4-т "Нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах", 20 дугаар зүйлийн 20.2.11-д "Өөрийн шууд удирдлагын доор ажиллаж байгаа нягтлан бодогчдын ажлын гүйцэтгэлийг хянах, мэргэшүүлэх, сургалтад хамруулах арга хэмжээ авах" гэсэнтэй нийцэхгүй байна.

#### **3.3.2 Эрсдэл:**

Цалингийн тооцооллын алдаа гарах, ашиглан үүсэх, дотоод хяналт сул байх

#### **3.3.3 Өгсөн зөвлөмж:**

Цалингийн программын сургалтад хамрагдаж цалин хөлсийг программаар тооцоолох;

#### **3.3.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:**

Аудитаар гарсан алдаа, зөрчлийг хүлээн зөвшөөрч зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

### **3.4 Тайлант хугацаанд хэрэгжүүлэх ерөнхий чиглэлтэй холбоотой асуудал**

#### **3.4.1. Илрүүлэлт:**

Албан ажлын автомашин хэрэглэх эрхгүй албан тушаалтан нь СЕХ-ны даргын 2005 оны 01 дүгээр захирамжаар ЗГ-ын автобазаас автомашин унаж, тайлант онд нийт 5.0 сая төгрөгийн үргүй зардал гаргасан нь ЗГ-ын 2015 оны 184 дүгээр тогтоолтой нийцэхгүй байна.

#### **3.4.2. Эрсдэл:**

ЗГ-ын тогтоолыг мөрдөхгүй байх, төсвийн хөрөнгийг үр ашиггүй төлөвлөж, зарцуулсан байх

#### **3.4.3. Өгсөн зөвлөмж:**

ЗГ-ын 2015 оны 184 дүгээр тогтоолтой нийцүүлэн зайлшгүй автомашин хэрэглэх тохиолдолд гэрээ байгуулан, дуудлагын автомашин ашиглаж байх;

#### **3.4.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:**

Аудитаар гарсан алдаа, зөрчлийг хүлээн зөвшөөрч зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 4.Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан

##### 4.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

		/мянган төгрөг/	
Код:	Тайлангийн үзүүлэлт	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
1	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	1,142,860.1	1,042,847.3
35	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	1,142,860.1	1,042,847.3
2	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	225,898.5	216,753.2
39	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	225,898.5	216,753.2
39200	<b>Биет хөрөнгө</b>	183,529.3	186,405.8
39300	<b>Биет бус хөрөнгө</b>	42,369.2	30,347.4
3	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>1,368,758.6</b>	<b>1,259,600.5</b>
5	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	1,368,758.6	1,259,600.5
51	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	1,368,758.6	1,259,600.5
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	14,410,826.1	14,410,826.1
51200	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	-13,043,279.0	-13,152,437.1
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,211.5	1,211.5
6	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>1,368,758.6</b>	<b>1,259,600.5</b>

## 4.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

		/мянган төгрөг/	
Код:	Тайлангийн үзүүлэлт	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,143,320.8</b>	<b>5,129,449.8</b>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	24.5	147.5
120	Нийтлэг татварын бус орлого	24.5	147.5
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,143,296.3	5,129,302.3
<b>II</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>1,261,100.8</b>	<b>1,305,377.5</b>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,261,100.8	1,305,377.5
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,163,535.4	1,101,052.3
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	426,360.8	450,170.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	50,437.0	56,255.2
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	5,800.0	6,130.0
2104	Хангамж, бараа материалын зардал	82,725.1	145,070.7
2107	Томилолт, зочны зардал	55,590.0	3,750.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	262,193.5	265,149.3
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	280,429.0	174,527.1
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	97,565.4	204,325.2
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>	<b>-117,780.0</b>	<b>3,824,072.3</b>
<b>V</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>-</b>	<b>3,933,230.4</b>
<b>VI</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)</b>	<b>-117,780.0</b>	<b>-109,158.1</b>

#### 4.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

		/мянган төгрөг/	
Код:	Тайлангийн үзүүлэлт	2018оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,143,320.8</b>	<b>5,129,449.8</b>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	24.5	147.5
120	Нийтлэг татварын бус орлого	24.5	147.5
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,143,296.3	5,129,302.3
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>1,143,320.8</b>	<b>1,130,665.6</b>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,143,320.8	1,130,665.6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,045,755.4	926,340.4
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	426,360.8	450,170.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	50,437.0	56,255.2
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	5,800.0	6,130.0
2104	Хангамж, бараа материалын зардал	47,075.1	44,459.6
2107	Томилолт, зочны зардал	55,873.8	4,100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	262,193.5	265,149.3
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	198,015.1	100,076.3
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	97,565.4	204,325.2
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>	-	<b>3,998,784.2</b>
<b>V</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)</b>	-	<b>3,998,784.2</b>
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	3,998,784.2
2200	Дотоод эх үүсвэрээр	-	3,998,784.2
<b>VI</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)</b>	-	<b>-3,998,784.2</b>
<b>VII</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН</b>	-	-
<b>VIII</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)</b>	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-



#### 4.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөг/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,486,538.6	-	1,486,538.6
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,486,538.6	-	1,486,538.6
9	Тайлант үеийн үр дүн	-117,780.0	-	-117,780.0
10	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,368,758.6	-	1,368,758.6
11	2019 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,368,758.6	-	1,368,758.6
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,368,758.6	-	1,368,758.6
19	Тайлант үеийн үр дүн	-109,158.1	-	-109,158.1
20	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,259,600.5	-	1,259,600.5

#### 4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	/мянган төгрөг/		
			Төсвийн гүйцэтгэл	Гүйцэтгэл зөрүү	Хувь
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>5,130,518.1</b>	<b>4,956,093.3</b>	<b>174,424.8</b>	<b>96.6</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,130,518.1</b>	<b>957,309.0</b>	<b>173,209.1</b>	<b>84.7</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,099,543.6</b>	<b>926,340.4</b>	<b>173,203.2</b>	<b>84.2</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>478,795.8</b>	<b>450,170.0</b>	<b>28,625.8</b>	<b>94.0</b>
210101	Үндсэн цалин	320,517.2	317,897.7	2,619.5	99.2
210102	Нэмэгдэл	128,668.6	103,674.3	24,994.3	80.6
210103	Унаа хоолны хөнгөлөлт	29,610.0	28,598.0	1,012.0	96.6
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>59,849.5</b>	<b>56,255.2</b>	<b>3,594.3</b>	<b>94.0</b>
210201	Тэтгэврийн даатгал	40,697.7	38,256.7	2,441.0	94.0
210202	Тэтгэмжийн даатгал	4,788.0	4,500.8	287.2	94.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,830.4	3,600.6	229.8	94.0
210204	Ажилгүйдлийн даатгал	957.6	899.7	57.9	94.0
210205	Эрүүл мэндийн даатгал	9,575.8	8,997.4	578.4	94.0
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>6,130.0</b>	<b>6,130.0</b>	<b>-</b>	<b>100.0</b>
210304	Байрны түрээс	6,130.0	6,130.0	-	100.0
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>45,692.4</b>	<b>44,459.6</b>	<b>1,232.8</b>	<b>97.3</b>
210401	Бичиг хэрэг	6,923.8	6,869.8	54.0	99.2
210402	Тээвэр, шатахуун	23,731.7	23,731.3	0.4	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	13,825.1	12,762.1	1,063.0	92.3
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,211.8	1,096.4	115.4	90.5
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>6,709.7</b>	<b>4,100.0</b>	<b>2,609.7</b>	<b>61.1</b>
210702	Дотоод албан томилолт	6,709.7	4,100.0	2,609.7	61.1
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>265,444.2</b>	<b>265,149.3</b>	<b>294.9</b>	<b>99.9</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	261,681.3	261,468.7	212.6	99.9
210803	Даатгалын үйлчилгээ	1,629.5	1,561.0	68.5	95.8
210804	Тээврийн хэрэгслийн татвар	199.0	185.6	13.4	93.3
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	66.0	66.0	0.0	100.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,808.4	1,808.0	0.4	100.0
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	60.0	60.0	-	100.0
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>236,922.0</b>	<b>100,076.3</b>	<b>136,845.7</b>	<b>42.2</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	220,092.0	91,409.9	128,682.1	41.5
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	16,830.0	8,666.3	8,163.7	51.5
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>30,974.5</b>	<b>30,968.6</b>	<b>5.9</b>	<b>100.0</b>
<b>2131</b>	<b>Засгийн газрын урсгал шилжүүлэг</b>	<b>29,474.5</b>	<b>29,473.9</b>	<b>0.6</b>	<b>100.0</b>
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	29,474.5	29,473.9	0.6	100.0
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>1,500.0</b>	<b>1,494.7</b>	<b>5.3</b>	<b>99.6</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,500.0	1,494.7	5.3	99.6
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>4,000,000.0</b>	<b>3,998,784.2</b>	<b>1,215.8</b>	<b>100.0</b>
222001	Тоног төхөөрөмж	4,000,000.0	3,998,784.2	1,215.8	100.0
<b>III</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>5,130,518.1</b>	<b>4,956,093.3</b>	<b>174,424.8</b>	<b>96.6</b>
<b>31</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>5,130,518.1</b>	<b>4,955,945.8</b>	<b>174,572.3</b>	<b>96.6</b>
310001	Улсын төсвөөс санхүүжих	5,130,518.1	4,955,945.8	174,572.3	96.6

<b>35</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>0</b>	<b>147.5</b>	<b>-147.5</b>	
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0	147.5	-147.5	
<b>6</b>	<b>ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ</b>	<b>62</b>	<b>62</b>	<b>-</b>	
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	<b>2</b>	<b>2</b>	<b>-</b>	
610001	Төсвийн байгууллага	2	2	-	
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>30</b>	<b>30</b>	<b>-</b>	
620001	Удирдах ажилтан	4	4	-	
620002	Гүйцэтгэх ажилтан	17	17	-	
620003	Үйлчлэх ажилтан	9	9	-	
620004	Гэрээт ажилтан	-	-	-	
<b>65</b>	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>30</b>	<b>30</b>	<b>-</b>	
650003	Ажлын албаны албан хаагч (АА)	19	19	-	
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	9	9	-	
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	2	2	-	

**5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт**

Огноо:	Аудитын нэр:	Сонгуулийн ерөнхий хорооны 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудит	Аудитын код:
2020.04.25			САГ-2020/18/СТА-ТЕ3
Шалгагдсан байгууллагын нэр:	Сонгуулийн ерөнхий хороо		Сая төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	СЕХ болон СЕХ-ны дэргэдэх Мэдээлэл, технологийн төвийн 2019 оны санхүүгийн тайланд тайлагнагдсан бараа материалын үлдэгдэл, хөрөнгийн хөдөлгөөнийг тооллогын тайлан, бүртгэлтэй тулгахад СЕХ-ны ажлын алба 11.8 сая, Мэдээлэл, технологийн төв 2.2 сая төгрөгийн хөрөнгийг худалдан авч, зарцуулсан хөдөлгөөнийг тус бүр тооллогын бүртгэлд дутуу бүртгэж, зөрүүтэй тайлагнасан.	14.0	Зөвлөмж	СЕХ-ны ажлын албаны дарга Ерөнхий нягтлан бодогч	Д.Баяндүүрэн Ж.Оюунгэрэл
2	СЕХ-ны дэргэдэх Мэдээлэл, технологийн төвийн 2019 оны санхүүгийн тайланд 2012 онд худалдан авсан, 2015 онд элэгдлээрээ өртгөө бүрэн нөхсөн, ашиглах боломжгүй болсон, нийт 17.5 сая төгрөгийн өртөгтэй албан хэрэг хөтлөлт, сонгогчийн бүртгэлийн серверийн программ хангамжууд бүртгэлтэй байгаа цаашид ашиглагдахгүй хөрөнгө байна.	17.5	Зөвлөмж	СЕХ-ны ажлын албаны дарга Ерөнхий нягтлан бодогч	Д.Баяндүүрэн Ж.Оюунгэрэл
3	Нийт урсгал зардлын гүйцэтгэлийн 47.0 хувь буюу 450.2 сая төгрөг нь цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардал байна. СЕХ болон СЕХ-ны дэргэдэх Мэдээлэл, технологийн төвийн ажилчдын цалин хөлсний тооцооллыг хянахад Санхүүгийн тооцоолох группийн "Acolous" программыг ашиглаж, гэрээний дагуу нэмэлт үйлчилгээг авч байгаа боловч цалинг цалингийн программаар бус excel дээр тооцоолсон, мөн ажиллагсдын цалингийн нэмэгдлийг салгалгүйгээр бөөн дүнгээр тооцсон нь цалингийн тооцооллыг шалгахад хүндрэлтэй бөгөөд цалинг илүү, дутуу тооцож олгох, тооцооллын алдаа үүсэх эрсдэлтэй байна.	-	Зөвлөмж	СЕХ-ны ажлын албаны дарга Ерөнхий нягтлан бодогч	Д.Баяндүүрэн Ж.Оюунгэрэл
4	Албан ажлын автомашин хэрэглэх эрхгүй албан тушаалтан нь СЕХ-ны даргын 2005 оны 01 дүгээр захирамжаар ЗГ-ын	5.0	Зөвлөмж	СЕХ-ны ажлын албаны дарга	Д.Баяндүүрэн

Сонгуулийн ерөнхий хорооны даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

	автобазаас автомашин унаж, тайлант онд нийт 5.0 сая төгрөгийн үргүй зардал гаргасан байна.			Ерөнхий нягтлан бодогч	Ж.Оюунгэрэл
	<b>Дүн</b>	<b>36.5</b>			